

**МОНГОЛ УЛС ДАХЬ УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГАЛТ,  
СУДАЛГААНЫ ТӨВ - МУИС-ИЙН УЛС ТӨР СУДЛАЛЫН ТЭНХИМИЙН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ТОВЧ ТОЙМ<sup>1</sup>**

Профессор Жанарын Төртогтох  
МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн профессор  
Ардчилал судлалын төвийн захирал  
[turo@num.edu.mn](mailto:turo@num.edu.mn)

Доктор Дагийдамбын Уртнасан  
МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн ахлах багш  
[urtnasan\\_d@num.edu.mn](mailto:urtnasan_d@num.edu.mn)

Ганбаатарын Баярчимэг  
МУИС, УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхимийн докторант  
[bayarchimeg@num.edu.mn](mailto:bayarchimeg@num.edu.mn)

**Хураангуй**

Энэхүү өгүүлэлд МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн үүсэн байгуулагдсан товч түүх, тус тэнхимийн эрдэмтэн багш нарын эрдэм шинжилгээний хамтын бүтээлийн тойм, тэнхимээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэн оруулав. Улс төр судлалын тэнхимийн түүхийг тоймлохдоо МУИС-ийн Нийгмийн ухааны факультетийн Шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхимийн товч түүх, Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны анхны тэнхимийн үүсэл, хөгжлийн товч түүх гэсэн хэсгүүдээр хураангуйлан илэрхийлэв. Улс төр судлалын тэнхимийн сургалт судалгааны бүтээлийг тоймлохдоо эрдэмтэн багш нарын эрдэм шинжилгээний хамтын бүтээлүүд, тэнхимээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлүүд, тэнхимийн багш нарын бичиж, хэвлүүлсэн нэг сэдэвт ном, зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл, дотоод, гадаадын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл, судалгааны төслийн тойм зэргээр нэгтгэн авч үзсэн болно. Хамтын бүтээл, судалгааны үр дүн зэргийг тухайлан авч үзсэн учраас улс төр судлалын тэнхимийн багш нарын бие даан хийсэн судалгаа, бүтээл зэргийг нэг бүрчлэн авч үзээгүй бөгөөд тэдгээрийг тоон мэдээлэлд нэгтгэн оруулсан болно.

Түлхүүр үг: [улс төр судлал](#), [улс төр судлалын тэнхим](#), [улс төрийн шинжлэх ухаан](#)

---

<sup>1</sup> Энэхүү өгүүлэл нь 2022 оны 9-р сарын 28-ны өдөр МУИС-ийн 80 жилийн ойд зориулан зохион байгуулсан “Монгол Улсын шинжлэх ухааны хөгжилд МУИС-ийн оруулсан хувь нэмэр: 80 жилийн босгон дээр” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд профессор Ж.Төртогтох, докторант Д.Уртнасан, докторант Г.Баярчимэг нарын хамтран бичиж хэлэлцүүлсэн илтгэлийн агуулгад үндэслэсэн бөгөөд Улс төр судлалын тэнхимд 2022-2025 оны хооронд хэвлэгдсэн зарим хамтын бүтээл, эрдэм шинжилгээний сэтгүүл, судалгааны үр дүн зэрэгт холбогдох тоо баримтаар нэмж баяжуулсан болно.

## Удиртгал

“Монгол Улс дахь улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны төв - МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрдэм шинжилгээний бүтээлийн товч тойм” сэдэвт энэхүү өгүүллийн зорилго нь МУИС-ийн улс төр судлалын тэнхимийн багш судлаачдын бичиж, хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлүүдийг нэгтгэн тоймлоход оршино. Ингэхдээ өгүүллийн эхний хэсэгт МУИС-ийн Нийгмийн ухааны факультетын Шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхим байгуулагдсан болон Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны анхны тэнхимийн үүсэл, хөгжлийн түүхийг МУИС-ийн 70 жил, НШУС-ийн 65 жил, Улс төр судлалын тэнхимийн 45 жилийн ойд зориулан МУИС-ийн профессор Ц.Ганболдын бичсэн “ШУКО-оос Улс төр судлал хүртэл” (УБ, 2012 он) бүтээлийн агуулгад тулгуурлан товч хураангуйлан оруулсан болно. Улмаар улс төр судлалын тэнхимийн багш нарын бичиж, хэвлүүлсэн нэг сэдэвт ном, зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл, дотоод, гадаадын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл, судалгааны төсөл зэрэг ажлуудын талаарх мэдээллийг тэнхимийн мэдээллийн санд байгаа хэвлэмэл бүтээлүүд, багш нарын товч намтар, танилцуулга, бүтээлийн жагсаалт зэрэгт тулгуурлан ойролцоогоор нэгтгэн гаргав.

Өгүүллийн дараагийн хэсэгт улс төр судлалын тэнхимээс монгол, англи хэлээр эрхлэн гаргаж ирсэн Политологи, Альтернатив, Contemporary Political Society зэрэг эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлүүдийн агуулга, мэдээлэлд үндэслэн нэгтгэн гаргав. Өгүүллийн эцэст тус өгүүллийг бичихэд ашигласан зарим хэвлэмэл бүтээлүүд, ном, эрдэм шинжилгээний сэтгүүл зэрэг эх сурвалжуудыг жагсаан бичив.

## **МУИС-ийн Нийгмийн ухааны факультетын Шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхимийн товч түүх<sup>2</sup>**

Монгол Улсын Их Сургуульд Эдийн засгийн дээд сургуулийг нэгтгэж, УИС-ын зохион байгуулалтыг өргөтгөн өөрчилсний дагуу Марксизм-Ленинизмын тэнхимээс Шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхим бие даан гарч, 1967 оны 10-р сарын 1-ээс үйл ажиллагаагаа эхэлжээ. Тэнхимийн анхны эрхлэгчээр их сургуульд 3 дахь жилдээ философи заасан багш Д.Содномгомбо болов. Их сургуульд ЗХУКН-ын түүх 7 жил, ШУКО 3 жил заасан Д.Гарамжав, Д.Лувсанцэрэн, ЗХУКН-ын түүх шинээр заах Ж.Гаваа нар багш болов. Тэнхим анх ажилд орж байхад Шинжлэх ухааны коммунизмын онолын хичээлээр дээд сургуульд үзэх сурах бичиг, гарын авлага, унших бичиг үгүй байв. Харин ЗХУКН-ын түүх, холбогдох материалууд орос, монгол хэл дээр элбэг байлаа. Тэнхим анх байгуулагдаж байхад эрдмийн зэрэг цолтой багш байсангүй. Тус тэнхим нь 1967-1968 оны хичээлийн жилд их сургуулийн 1 ба төгсөх курсийн 850 гаруй оюутанд 2500 гаруй цагийн хичээл зааж байсан бол 1979-1980 оны хичээлийн жилд 2000 гаруй оюутанд 11000 гаруй цагийн хичээл заадаг болжээ.

1969-1970 оны хичээлийн жилд тэнхимийн эрхлэгч Д.Содномгомбо философийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан нь тэнхимийн сургалт эрдэм шинжилгээний түвшинд чухал алхам болов. 1972 онд тус тэнхимийн дэргэд, оюутны хүмүүжлийн асуудал судлах нийгмийн тодорхой судалгааны лаборатори байгуулагдав.

---

<sup>2</sup> Өгүүллийн энэ хэсгийг МУИС-ийн 70 жил, НШУС-ийн 65 жил, Улс төр судлалын тэнхимийн 45 жилийн ойд зориулан МУИС-ийн профессор Ц.Ганболдын бичсэн “ШУКО-оос Улс төр судлал хүртэл” (УБ, 2012 он, 40-52 дахь тал) бүтээлийн агуулгаас хураангуйлан тоймлов.

Тус тэнхим нь сургалтын материаллаг баазыг сайжруулах багш нарын мэргэжил заах аргыг дээшлүүлэхийн тулд 1967-1968 оны хичээлийн жилээс ШУКО-ын сурах бичиг, орос хэлнээс орчуулан зохиох ажилд орж 1969 онд хэвлүүлсэн. Тус тэнхимийн боловсруулсан программ, төлөвлөгөө, сэдвийг бусад дээд сургуулиуд авч мөрддөг байжээ. 1973 онд ЗХУКН-ын түүхийн сурах бичгийг орчуулж, ШУКО-ын толь бичгийг тэнхимийн багш, бусад газрын эрдэмтэд, мэргэжилтний хүчээр хэвлүүлсэн байна. Энэ бүхний үндсэн дээр ЗХУКН-ын түүх, ШУКО-ын хичээлээр БНМАУ-ын их дээд сургуулиудад мөрдөх программ, семинарын хичээлийн төлөвлөгөө сурах бичиг унших ном үндэсний хэл дээр бий болсон. Тус тэнхим шинжлэх ухааны коммунизмын онол /ШУКО/, Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын түүх хичээлийг зааж үндсэн сурах бичгүүдийг бичиж хэд хэдэн удаа нэмэлт засвар хийж хэвлүүлсний зэрэгцээ эдгээр хичээлийн семинарын төлөвлөгөө гарын авлагуудыг хэвлүүлж, тэдгээр ном сурах бичгүүд гарын авлагуудыг монголын бүх их дээд сургуулиудын тухайн мэргэжлийн багш оюутнууд хэрэглэж байлаа.



Ш.Содном 1990 онд “Хөдөлмөрт хандах социалист харилцааны төлөвшилтийн диалектик” сэдвээр, С.Базарпүрэв 1990 онд “Оюутан залуусын нийгмийн идэвхтэй байр суурийг төлөвшүүлэх асуудал” сэдвээр докторын зэрэг хамгаалан тэнхимдээ багшилсан. 1990-1991 онд манай тэнхимийн аспирант Ц.Ганболд тухайн үеийн Улсын бага хурлын орлогч дарга, Үндсэн хууль боловсруулах комиссын орлогч дарга доктор К.Зардыханы удирдлагаар Монгол улсын Үндсэн хууль боловсруулах ажилд оролцож “Монгол Улсын Их Цааз” (Үндсэн хууль) төсөл 1, “Монгол Улсын Их Цааз” төсөл 2 баримт бичгүүд дээр ажиллаж байлаа. Ц.Ганболд 1991 онд “Ардын уламжлал ба эх оронч ухамсар” сэдвээр докторын зэрэг хамгаалж тэнхимдээ багшаар үлдсэн байна.

### **Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны анхны тэнхимийн үүсэл, хөгжлийн товч түүх<sup>3</sup>**

1989 оны сүүлч, 1990 оны эхнээс Монголын нийгэм улс төрийн тогтолцоо өөрчлөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор 1990-1991 оны хичээлийн жилээс МАХН-ын түүх, ЗХУКН-ын түүх, Улс төрийн эдийн засгийн ухаан, ШУКО зэрэг хичээлийг их сургуулийн хөтөлбөрөөс хасаж эхэлжээ. Ингээд 1990-1991 оны хичээлийн жилд зарим их дээд сургуулиудад дээрх хичээлүүдийг орохыг зогсоож, шинэ хичээлүүд орох бэлтгэл ажлууд хийгдсэн. Ингээд их дээд сургуулийн зарим багш нарыг Польш, ЗХУ-д явуулж мэргэжил дээшлүүлж, МУИС-ийн ШУКО-ын тэнхимийн суурин дээр Улс төр судлалын тэнхимийг байгуулах бэлтгэл ажил 1990 онд хийгджээ. 1992 онд Улсын Бага Хурлын дэргэдэх Төр Нийгэм Судлалын Академи (одоогийн Удирдлагын академи)-ийн төрийн удирдлагын тэнхимд богино хугацааны курс зохион байгуулагдаж, түүнд их дээд сургуульд улс төр судлал заах багш нар хамрагджээ. 1991-1992 оны хичээлийн жилд ШУКО-ын оронд Улс төр судлал, УТЭЗУ-ны оронд эдийн засгийн онол, марксист-ленинист философийн оронд гүн ухаан, МАХН-ын

<sup>3</sup> Өгүүллийн энэ хэсгийг МУИС-ийн 70 жил, НШУС-ийн 65 жил, Улс төр судлалын тэнхимийн 45 жилийн ойд зориулан МУИС-ийн профессор Ц.Ганболдын бичсэн “ШУКО-оос Улс төр судлал хүртэл” (УБ, 2012 он, 58-73 дахь тал) бүтээлийн агуулгаас хураангуйлан тоймлов.

түүхийн оронд Монголын түүх зэрэг хичээлүүдийг заах нь зүйтэй гэж тухайн үеийн БШУЯ-ны сайдын шийдвэр гарсан байна.

1991 онд МУИС-ийн захирлын тушаалаар хуучин ШУКО-ын тэнхимийн суурин дээр улс төр судлалын тэнхим байгуулагдаж, тэнхимийн эрхлэгчээр НУФ-ын декан дэд доктор Ш.Содном хавсран ажиллахаар томилогджээ. Улс төр судлалын тэнхимд 7 багш ажиллаж байсан ба тухайн үед Политехникийн дээд сургууль, УБДС, АУДС, ЦДС, ХААДС зэрэг төрийн өмчийн томоохон дээд сургууль, зарим техникумын улс төр судлалын багш нар МУИС-ийн улс төр судлалын тэнхимд төвлөрч мэргэжлийн сургалт эрдэм шинжилгээний болон заах аргын семинарууд явуулж тус тэнхим улсын хэмжээний сургалт эрдэм шинжилгээний гол төв болж байсан. 1991 оны 12 дугаар сараас Ц.Ганболд тэнхимийн орлогч эрхлэгчээр томилогдож, МУИС-ийн захирлын 1992 оны 5-р сарын 6-ны өдрийн 279 дүгээр тушаалаар Ш.Содном НУФ-ын эрдмийн зөвлөлийн дарга, Ц.Ганболд эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогджээ.

1992 онд улс төр судлал, социологи, угсаатан судлалын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх зорилгоор нийгмийн судалгааны төвийг байгуулж, төвийн эрхлэгчээр дэд доктор Л.Бат-Очирыг томилж, дараа нь дэд доктор Х.Нямбуу төвийн эрхлэгчээр ажиллаж байгаад хожим угсаатны зүйн тэнхим болон өөрчлөгджээ.

1993 онд МУИС-д улс төр судлалын салбар байгуулагдсан нь улс төрийн шинжлэх ухааны мэргэжлийн боловсон хүчнийг эх орондоо бэлтгэх анхны том алхам болсон юм. 1997 онд улс төрийн шинжлэх ухааны бакалаврын дипломтой анхны 13 оюутан төгссөн. 1996 онд анхны магистр Ж.Мэндээ, Д.Оюунчимэг, 1997 онд Х.Ганбаатар, Г.Цэнд-Аюуш, 1999 онд Ж.Төртогтох, Д.Бадамдаш, Д.Мөнх-Очир, Д.Ундрах, А.Нямдолжин, Ц.Мөнхцэцэг нар магистрын зэрэг хамгаалсан.

1994 онд Москвагийн их сургуульд А.Юндэндорж Улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж, 1998 онд УБИС-ийн тэнхимийн эрхлэгч Л.Пүрэвдорж улс төрийн шинжлэх ухааны анхны докторын зэрэг хамгаалжээ.



1997-1998 оны хичээлийн жилээс улс төрийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийг ШУА-ийн ФСЭХ-д түшиглүүлэн философи, социологи, улс төр судлалаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулагдсан. Энэ зөвлөл дээр Л.Пүрэвдорж, Ю.Атар, Х.Цолмон, Т.Гантулга нар хамгаалсан. 2002 онд БСШУЯ-ны сайдын 32-р тушаалаар улс төрийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах улсын хэмжээний нэгдсэн зөвлөл байгуулагджээ. Энэ зөвлөл улс төр судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалуулдаг анхны нэгдсэн зөвлөл болсон юм. Энэ нь бидний хувьд докторын зэргийн сургалт бие даан явуулж, хамгаалуулах эрхээ баталгаажуулахад нэг том алхам болсон билээ. Улсын хэмжээний энэхүү нэгдсэн зөвлөл дээр анх улс төр судлалын тэнхимийн багш Ж.Төртогтох доктор (Ph.D)-ын зэргээ хамгаалсан юм<sup>4</sup>.

МУИС-ийн улс төр судлалын тэнхимийн 1997 оны анхны төгсөгчдийн санаачлагаар 2003 оны 6-р сард МУИС-ийн хичээлийн 2-р байрны 226 тоот өрөөнд Монголын улс төр судлалын холбоо анх удаа байгуулагдсан бөгөөд 2003 оны 10-р сард улс төр судлалын тэнхимийн 2002 оны төгсөгчдийн төлөөллийн санаачлагаар уг холбоог өргөжүүлэн зохион байгуулсан байна. 2005 онд доктор А.Цанжид нарын улс төр судлаач эрдэмтдийн санаачлагаар Монголын улс төрийн шинжлэх ухааны холбоо, 2010 оны 9-р сард профессор Ц.Ганболдын үүсгэл санаачлагаар Монголын улс төр судлаачдын нэгдсэн холбоо тус тус байгуулагджээ.

---

<sup>4</sup> Ц.Ганболд, “ШУКО-оос Улс төр судлал хүртэл” (УБ, 2012 он, 67-69 дэх тал)

2006 оны 5-р сарын 10-нд Д.Мөнх-Очир, Ж.Төртогтох, О.Машбат, С.Мөнхбат, Д.Бадамдаш, С.Гантулга нарын улс төр судлал, түүх, математик, эрх зүйн салбарын залуу багш нарын хамтын санаачилгаар МУИС-д Орчин үеийн улс төрийн судалгааны төв байгуулагдан 2012 он хүртэл ажилласан.



Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор Ж.Төртогтох, магистрант Д.Уртнасан нарын санаачлага, зүтгэлээр 2020 оны 2-р сарын 5-нд МУИС-ийн ШУС-д (2023 оны 11-р сарын 1-нээс МУИС-ийн УТСОУХНУС-ийн харьяанд шилжсэн) Ардчилал судлалын төв байгуулагдаж, захирлаар профессор Ж.Төртогтох томилогдон ажиллаж байна.

Хэдийгээр дэлхий нийтийг хамарсан цар тахал, хөл хорио эхлэх эхэн үед байгуулагдсан боловч тус төвөөс санаачлан 2020-2021 онд Нээлттэй Нийгэм Форум, Конрад Аденауэр Сан зэрэг хэд хэдэн байгууллагатай хамтран ардчилал, сонгуулийн асуудлаар судалгааны ажил хийж, үр дүнг олон нийтэд хүргэсэн. Ардчилал судлалын төвөөс 2021-2024 онд Финландын Турку Их Сургууль, Австрийн Венийн Их Сургууль, БНСУ-ын Сөүлийн Үндэсний Их Сургууль, Корей Их Сургууль, Донггүк Их Сургууль, АНУ-ын Бей Атлант Их Сургууль, Вашингтоны Их Сургууль, Колорадогийн Их Сургууль, Стэнфордын Их Сургууль, БНХАУ-ын Ренмин Их Сургууль, БНЧУ-ын Прагийн Метрополитан Их Сургууль, Английн Ноттингхэмийн Их Сургууль, Тайванийн Үндэсний Их Сургууль зэрэг нэр хүндтэй их сургуулиудын улс төрийн шинжлэх ухаан, ардчилал судлалын эрдэмтэн судлаачдыг урьж, зочин багшийн лекц 10 гаруй удаа зохион байгуулсан. 2022-2023 оны хичээлийн жилийн намрын улирлаас эхлэн магистрант, докторантуудад зориулсан мэргэжлийн судалгааны семинарыг хичээлийн жилийн улирал бүр 12-оос доошгүй удаа зохион байгуулж байна. Мөн өнгөрсөн хугацаанд МУИС-ийн холбогдох журам, шаардлагад нийцүүлэн судалгааны туслах (ассистантшип)-аар давхардсан тоогоор нийт 8 магистрант, 10 докторант ажилласан бөгөөд тус төв дээр судалгааны ажилдаа холбогдох дата, мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бэлтгэх, танилцуулах, хэвлүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэжээ.

Ардчилал судлалын төв нь БНСУ-ын Корей Их Сургууль, Ёнсей Их Сургууль зэрэг нэр хүндтэй их сургуулиудын Улс төрийн шинжлэх ухааны тэнхим, Социологийн тэнхим, Өрнө Дорно судлалын төв зэрэг байгууллагатай хамтран 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн Зүүн Азийн улс төр, Солонгосын хойгийн улс төр, Солонгосын нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудаар нийт 16 удаагийн 670 гаруй кредит цагийн онлайн цуврал лекц, сургалт оюутнуудад зориулан зохион байгуулж, тэдгээрт давхардсан тоогоор улс төр судлал, олон улсын харилцаа, эрх зүй, социологи, эдийн засгийн салбарын 214 оюутан, магистрант, докторант хамрагдсан байна. Тэдгээр суралцагчдаас 11 оюутан шалгарч олон улсын зуны сургуульд бүрэн тэтгэлэгтэй хамрагджээ.

**POLITOLOGY**

CURRENT ARCHIVES ANNOUNCEMENTS ABOUT ▾

HOME / Contact

### Contact

МУИС-ийн хичээлийн V байр 307 тоот, Улс төр судлалын тэнхим

Principal Contact	Support Contact
ТӨРТОГТОХ Жапал Ерөнхий эрхлэгч	УРТНАСАН Дагийдамба
Phone 77307730-2317	Phone +97680414141
<a href="mailto:turo@num.edu.mn">turo@num.edu.mn</a>	<a href="mailto:urtnasan_d@num.edu.mn">urtnasan_d@num.edu.mn</a>

Түүнчлэн, холбогдох журам, тавигдах шаардлагын хүрээнд Политологи сэтгүүлийг 21 дэх дугаараас нь эхлэн Улс төр судлалын тэнхимийн хамтарсан статустайгаар эрхлэн гаргаж, сэтгүүлийг давхар хянан магадлагаатай болгох, онлайн хэлбэрт оруулж, олон улсын бүртгэлийн

DOI дугаарт бүртгүүлэх зэрэг ажлуудыг амжилттай хэрэгжүүлж эхлээд байна.

## Улс төр судлалын тэнхимийн багш нарын бичиж, хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тойм


Улс төр судлалын тэнхимийн багш нар өнгөрсөн хугацаанд улс төрийн шинжлэх ухааны үндсэн сэдвүүд болон дэд салбарууд, хавсарга сэдэв, чиглэлийн хүрээнд эрдэм шинжилгээний бүтээлүүдийг тус тусдаа ба хамтран бичиж туурвиж ирлээ. Тухайлбал тус тэнхимийн багш нарын хамтран болон дангаар бичиж хэвлүүлсэн ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл ойролцоогоор нийт 100 орчим байгаа бол дотоод гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд 494 өгүүлэл бичиж хэвлүүлжээ. Мөн үндэсний хэмжээнд болон АНУ, ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, Казахстан, Киргизстан, Швед, Франц, Финлянд, Чех, ХБНГУ, Унгар, Канад, Их Британи, Испани, Энэтхэг, Румын, Литва зэрэг улсуудад болсон олон улсын түвшний эрдэм шинжилгээний бага хурал, семинар, воркшоп зэрэгт тэнхимийн багш нар ойролцоогоор 400 гаруй илтгэл хэлэлцүүлсэн байна. Үүний зэрэгцээ судалгааны ажил, эрдэм шинжилгээний төсөл, МУИС-ийн болон дотоод, гадаадын бусад байгууллагын захиалгат давхардсан тоогоор нийт 150 гаруй судалгааны ажил, төслийг тэнхимийн багш нар хамтарч ба дангаар амжилттай хийж гүйцэтгэж ирсэн байна.<sup>5</sup> Дээрх олон төрлийн судалгаа шинжилгээний бүтээлүүдээс юуны өмнө тэнхимийн эрдэмтэн багш нарын эрдэм шинжилгээний хамтын бүтээлийг тоймлож авч үзье.

<sup>5</sup> Багш нарын бичиж хэвлүүлсэн бүтээлүүдийн тоог тэнхимийн мэдээллийн санд байгаа хэвлэмэл бүтээлүүд, багш нарын товч намтар, танилцуулга, бүтээлийн жагсаалт зэрэгт тулгуурлан ойролцоогоор нэгтгэн гаргав. Иймд зарим тоо мэдээлэл тодорхой хэмжээнд зөрүүтэй байх боломжтой.

Улс төр судлалын тэнхимийн багш нар улс төрийн шинжлэх ухааны агуулгын хүрээнд нийт 100 орчим нэг сэдэвт зохиол, сурах бичиг дангаар болон хамтран бичиж хэвлүүлжээ. Тухайлбал, тэнхимийн багш нар хамтран “Улс төрийн шинжлэх ухаан” сурах бичгийг анх 2001 онд бичиж хэвлүүлсэн бөгөөд 2010, 2014 онд нэмж засварлан хэвлүүлж байжээ. Монголын их дээд сургуулийн холбогдох мэргэжлийн багш, оюутнууд өргөн олон уншигчдад зориулан гаргасан энэхүү ном нь тус тэнхимийн багш нарын хамтран бүтээсэн улс төрийн шинжлэх ухааны сурах бичиг зохиож уншигчдын хүртээл болгосон анхны оролдлого байжээ. Манай улсын их, дээд сургуулиудын улс төр судлалын сургалтын практикт тулгамдсан зарим асуудлууд тухалбал хичээлийн агуулгыг жигдрүүлэх, мэргэжлийн багш нараар хичээл заалгах, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, Монгол хэл дээр хэвлэгдсэн улс төр судлалын сурах бичиг, гарын авлага дутагдалтай байсан зэрэг хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор тус бүтээлийг бичиж хэвлүүлсэн байна.

Уг бүтээл нь дараах үндсэн 18 бүлэг, 64 дэд сэдвээс бүрдсэн. Үүнд:

- Улс төрийн сэтгэлгээний эх үндэс
- Улс төрийн шинжлэх ухааны үндсэн парадигмууд
- Улс төрийн засаглал
- Улс төрийн бодлогын социал үндэс
- Улс төрийн засаглалын нийгмийн субьектүүд
- Улс төрийн хошуучлал
- Нийгмийн улс төрийн систем
- Улс төрийн дэглэм
- Сонгуулийн систем
- Төр – улс төрийн системийн үндсэн институт болох нь
- Улс төрийн нам, намын систем
- Улс төрийн соёл, нийгэмшилт
- Улс төрийн үйл байдал ба оролцоо
- Орчин үеийн улс төрийн үзэл суртал
- Улс төрийн хөгжил ба модернизаци
- Улс төрийн мөргөлдөөн ба хямрал
- Геополитик




Улс төрийн шинжлэх ухааны уг сурах бичгийг бичихэд орос, англи зэрэг хэл дээр хэвлэгдсэн давхардсан тоогоор нийт 200 орчим эх зохиол, сурах бичиг, бусад холбогдох материалыг ашиглан бичиж, профессор Ц.Ганболд, профессор Ш.Содном, профессор Д.Содномгомбо, доктор А.Юндэндорж нар хянан засварлаж, номын ерөнхий редактораар профессор Ц.Ганболд ажилласан байна.



Орчин цагийн улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны институтчилэл Монголд улс төрийн ардчилалжилт, ардчиллын хөгжилтэй зэрэгцэн үүсэн хөгжиж эхэлснээс хойших 30 гаруй жилийн хугацаанд улс төрийн шинжлэх ухааны дагнасан нэвтэрхий толь бүтээгдээгүй байсан орон зайг нөхөн МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн санаачлагчаар Монголын нийгэм, улс төр судлаачдын хамтран бүтээсэн “Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг”-ийг 2020 онд анх хэвлүүлсэн. Тус бүтээлийг зохиоход нийт 35 зохиогч

оролцон, ерөнхий редактораар профессор Ж.Төртогтох, БШУЯ-ны шинжлэх ухаан, технологийн газрын дарга С.Мөнхбат нар ажилласан бөгөөд уг бүтээлд улс төрийн шинжлэх ухааны нийт 1000 гаруй нэр томьёо, ойлголт, ухагдахууныг тайлбарлан бичсэн.

Улс төрийн шинжлэх ухаан улс төрийн тодорхой тал, төлөв байдал, түүнээс нийгэмтэй харьцах харилцааг судалдаг тусгай салбар ухаануудыг нэгтгэж байдаг. Тиймээс Улс төр судлалын тэнхимийн багш нар улс төрийн шинжлэх ухааны салбарын судалгааны бүтээлд хамтран зохиогчоор оролцохоос гадна дотоод, гадаадын нэр хүнд бүхий эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагаас эрхлэн гаргасан сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээлийн редактор болон орчуулагчийн багт ажиллаж ирсэн. Тухайлбал, 2022 онд ОХУ-ын ГХЯ-ны дэргэдэх Москвагийн олон улсын харилцааны дээд сургуулийн улс төрийн шинжлэх ухааны дэд профессор И.Ю.Окуневийн “Улс төрийн газарзүй” сэдэвт улс төр, олон улсын харилцаа, бүс нутаг судлал, газарзүй чиглэлээр суралцдаг их дээд сургуулийн оюутны сурах бичгийн орчуулгын багт Улс төр судлалын тэнхимийн профессор Ж.Төртогтох, профессор С.Мөнхбат, дэд профессор Ц.Батболд нар ажилласан.




Мөн 2024 онд ХБНГУ-ын Конрад-Аденауэр сангийн Монгол дахь төлөөлөгчийн газраас эрхлэн гаргасан “Захиргааны шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь (Хоёр дахь хэвлэл)” бичигт профессор Ж.Төртогтох, дэд профессор Д.Ундрах нар зохиогчоор оролцжээ.

Улс төр судлалын тэнхимийн дэргэдэх Орчин үеийн улс төрийн судалгааны төвийн багш, судлаач нар хамтран 2007 онд “Авилгалыг дэмжигч болон хориглогч хүчин зүйлс” сэдэвт судалгааны ажлын үр дүнг хэвлэн нийтэлсэн нь Монгол дахь авлигын асуудлын талаарх шинжлэх ухааны онол, арга зүйн үндэстэй судалгаа, шинжилгээг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр болсон байна. Уг судалгааны үр дүн нь нийгэмд шударга, чөлөөт өрсөлдөөнийг дэвшүүлэхэд нөлөөлөх, нийгмийн зүгээс төр засгийн эрх мэдэл бүхий албан тушаалтнуудад тавих шаардлагыг хүчтэй, үр дүнтэй болгох, авлигатай тэмцэх талаар төр засгийн зүгээс шийдвэр гаргах үйл явцад олон түмний санаа бодлыг тусгуулах зэрэг ач холбогдолтой болсон байна.



МУИС-ийн 70 жил, НШУС-ийн 65 жил, Улс төр судлалын тэнхимийн 45 жилийн ойд зориулан “Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг /XX зуун/” бүтээлийг 2012 онд тэнхимийн багш нар хамтран бичиж хэвлүүлсэн. XX зууны өрнөдийн улс төрийн онолчдын намтар, бүтээлээс орчуулж эмхэтгэсэн уг хамтын бүтээлд нийт 23 сэтгэгчдийн бүтээлүүдийн орчуулга, зарим бүтээлийн агуулгыг тайлбарласан байна.

Монголын улс төр судлаачдын нэгдсэн холбоо санаачлан 2010 оноос жил бүр улс төрийн шинжлэх ухааны тодорхой сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж иржээ. Тус эрдэм шинжилгээний хурлыг МУИС-ийн Улс төр судлалын тэнхим нь МУБИС-ийн Улс төр, социологийн тэнхим, ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургууль, ШУА-ийн ОУСХ, ФСЭХ зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулж ирсэн. 2010 онд “Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжил, хандлага” сэдвийн хүрээнд Улс төрийн онол, арга зүй, үйл явц, Улс төрийн социологи, Олон улсын харилцаа, Улс төрийн боловсрол ба заах арга гэсэн дэд хэсгүүдээр зохион байгуулж нийт 22 илтгэл хэлэлцүүлсэн. 2011 онд “Монголын улс төр: асуудал, эрэл, шийдэл” сэдвийн хүрээнд зохион байгуулж нийт 14 илтгэл, 2012 онд “Ардчилал: асуудал, эрэл, шийдэл” сэдвийн хүрээнд нийт 12 илтгэл, 2014 онд “Улс төрийн нам: асуудал, эрэл, шийдэл” сэдвийн хүрээнд нийт 13 илтгэл тус тус хэлэлцүүлжээ.



Улс төр судлалын тэнхимээс Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын улс төр судлаачдын нэгдсэн холбоотой хамтран 2019 онд “Парламентын институтийн улс төр, эрх зүйн шинжилгээ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж парламентын засаглал, парламентын хянан шалгах бүрэн эрх, парламентын гишүүний ёс зүй, УИХ-ын сонгууль, засаглалын хэлбэр зэрэг асуудлуудын хүрээнд илтгэл хэлэлцүүлсэн бол 2020 онд “Улс төрийн

намын улс төр эрх зүйн шинжилгээ” сэдвээр зохион байгуулж, улс төрийн намын санхүүжилт, намын гишүүнчлэл, намын болон сонгуулийн санхүүжилт, улс төрийн намын хөгжил, шинэчлэл зэрэг асуудлуудаар илтгэл хэлэлцүүлжээ.


2017 оноос Улс төр судлалын тэнхим нь ХБНГУ-ын Конрад-Аденауэр сангийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран жил бүр бодлогын судалгаа зохион байгуулж судалгааны үр дүн, бодлогын зөвлөмжийг хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгож ирлээ. Тухайлбал, 2017 онд “Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо” сэдвийн хүрээнд зохион байгуулж, үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо, төв орон нутгийн харилцаа, нутгийн удирдлагын тогтолцооны эрх зүй, нутгийн удирдлага дахь сонгууль, томилгоо, эрх мэдлийн хуваарилалт, төрийн санхүүгийн хяналт зэрэг асуудлуудаар бодлогын судалгаа хийсэн бол 2018 онд “Монгол улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа” сэдвийн



орон нутгийн хүрээнд УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүх зэрэгт холбогдох асуудлуудаар, 2019 онд “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь” сэдвийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа, засаг даргын эрх, чиг үүрэг, баг, хорооны эрх зүйн байдал, хот тосгоны удирдлагын тогтолцоо, орон нутгийн тогтвортой хөгжил, орон нутаг дахь иргэдийн оролцоо зэрэгт холбогдох


асуудлуудаар, 2020 онд “Монгол дахь ардчилал, иргэнийн нийгмийн өнөөгийн байдлын нийгэм – улс төрийн судалгаа” сэдвийн хүрээнд улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, улс төрөөс хараат бус олон нийтийн хэвлэл мэдээлэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо, засаглалын цахим шилжилт, төсвийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын хөгжил, хандлага, ардчиллын бэхжилт, сорил зэрэг асуудлуудаар, 2021 онд “Монгол дахь засаглал, институт, оролцоо, тэгш байдлын тулгамдсан асуудал, цаашдын хандлага” сэдвийн хүрээнд улс төрийн намуудын санхүүжилт, улс төрийн хүрээнд авлигын нөхцөл байдал, нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш байдлыг хангах талаарх төрийн бодлого зэрэг асуудлуудаар, 2022 онд “Цахим засаглал: төрийн үйлчилгээ, шийдвэр гаргах үйл явц, мэдээлэл харилцааг цахимжуулах боломж” сэдвийн хүрээнд иргэдийн






цахим оролцоо, төрийн цахим үйлчилгээний өнөөгийн төлөв байдал, нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын нөлөөллийн шинжилгээ, цахим засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилтийн шинжилгээ, цаашдын чиг хандлага, шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хангах нь: олон улсын туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал зэрэг асуудлаар, 2023 онд “Монголд төлөөллийн ардчиллын институтууд чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байна вэ?” сэдвийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоох институцийн төлөөллийн чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэх судалгаа, бүх түвшний төлөөллийн институцэд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх боломж, арга зам, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөх чиг үүрэг, түүний хэрэгжилтийн судалгаа зэрэг асуудлаар тус тус бодлогын судалгаа хийж, үр дүн, зөвлөмжийг хэвлэн нийтэлжээ. Дээрх судалгаануудыг давхардсан тоогоор нийт 20 зөвлөх, 38 судлаач хамтран хийж гүйцэтгэсэн байна. 2024-2025 онд “Үндсэн хуульт ёсны тулгамдсан асуудал” сэдвээр бодлогын судалгааг хийж гүйцэтгэж байна.

Монгол дахь Конрад-Аденауэр сангийн дэргэдэх Төрийн байгуулалтын экспертний зөвлөлд улс төр судлалын тэнхимээс төлөөлөн оролцдог бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд “Төрийн байгуулал судлал” сэтгүүлийг төрийн байгууллын институтууд, нийгэм улс төр судлал, төрийн захиргаа, төрийн удирдлагын асуудлуудаар хэвлүүлж ирсэн бөгөөд 2018 оны анхны дугаарт 10 судлаачийн 9 өгүүлэл, 2020 оны цахим дугаарт 11 судлаачийн 9 өгүүлэл, 2021 оны 3 дахь дугаарт 13 өгүүлэл, 2022 оны 5 дахь дугаарт 7 судлаачийн 6 өгүүлэл, 2024 оны 6 дахь дугаарт 9 судлаачийн 6 өгүүлэл, 2 ярилцлага, 2024 оны 7 дахь дугаарт 9 судлаачийн 8 өгүүлэл, 2024 оны 8 дахь дугаарт 15 судлаачийн 11 өгүүлэл тус тус нийтлэгдсэн байна.






2020 онд МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлдэг “МУИС-ийн профессорын эрдмийн өв”-д Монгол улсын гавьяат багш, профессор Дашийн Содномгомбын эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлийг 2 боть болгон нийтлүүлсэн байна. “Философи, улс төрийн философийн мэдлэгт” хэмээх тэргүүн ботид “Мэдлэгийн диалектик процесс” /1966/, “Философи” /2004/, “Глобал ертөнцийн тухай шинжлэх ухааны үүсэл, хөгжил,

арга зүйн зарим асуудал” /2005/, “Улс төрийн философийг тоймлох нь” /2007/ зэрэг философи, улс төрийн философийн үндсэн асуудлуудад хамаарах бүтээлүүд, “Улс төр судлалын мэдлэгт” хэмээх 2 дугаар ботид “Улс төрийн товч толь” /1996/, “Ардчиллын мөн чанар, түүхэн хэлбэрүүд” /1995/, “Улс төрийн шинжлэх ухаан” /2001/ хамтын бүтээлд орсон “Улс төрийн үзэл суртал”, “Улс төрийн соёл, нийгэмшилт” сэдэвт бие даасан бүлгүүд, мөн “Улс төрийн соёл, түүний Монгол дахь төлөвшлийн асуудал”, “Монгол улсын үндэсний аюулгүй байдал, түүний хангах зарим асуудал” /2000/ зэрэг улс төр судлалын тулгуур асуудлуудад холбогдох бүтээлүүдийг тус тус эмхэтгэн хэвлүүлсэн болно. Эдгээр бүтээлүүд нь их дээд сургуулийн улс төр судлал, философийн сургалт судалгааны үйлд үнэтэй эх сурвалж, хэрэглэгдэхүүн болсоор байгаа билээ.

Мөн МУИС-ийн профессор Ширчингийн Содномын эрдэм шинжилгээний эмхэтгэлийн бүтээлийг “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цувралд “Улс төр судлалын онол, практикийн асуудлууд” хэмээх сэдвээр нэгэн боть болгон хэвлүүлсэн. Энэхүү ботийн “Улс төр судлалын үндэс” хэмээх нэгдүгээр бүлэгт “Улс төрийн мэдлэгийн үндэс” /1986/ нэг сэдэвт бүтээл, “Улс төрийн шинжлэх ухаан” хамтын бүтээлд бие даасан бүлэг болон орсон “Улс төр судлал – шинжлэх ухаан болох нь”, “Улс төрийн засаглал” /2001/ хэмээх бүтээлүүд, “Монголын улс төрийн үйл явц ба улс төрийн харилцаа” хэмээх хоёрдугаар бүлэгт “Монгол дахь ардчилах үйл явц ба сонгууль” /2009/, “Пост коммунист шилжилт: үзэл баримтлал ба үйл явц” /2002/, “Сонгогчдын үйл байдлын өөрчлөлт: хүчин зүйл ба хандлага” /2005/ зэрэг өгүүлүүд, түүнчлэн “Монгол улсын түүх” /2010/ ном дахь “Монголын улс төрийн харилцааны түүхийн өрнөл, хөгжил” сэдэвт бүлгийг эмхэтгэн хэвлүүлсэн болно. Эдгээр нь их дээд сургуулийн багш, оюутан, сонирхон судлагчдад улс төр судлал, ардчилал, улс төрийн түүхийн талаар өргөн мэдлэг олж авахад чухал ач холбогдолтой бүтээл, сургалт судалгааны үйлд үнэтэй эх сурвалж, хэрэглэгдэхүүн болсоор байна.





Монгол улсын гавьяат багш, профессор Цэрэнгийн Ганболдын эрдэм шинжилгээний бүтээлийг 2020 онд “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цувралаар “Монголын улс төр: онол, номлол, нийтлэл”, “Монголын улс төр: уламжлал, шинэчлэл, тэмдэглэл”, “Монголын улс төр: судалгаа, шинжилгээ, үнэлгээ” гэсэн 3 боть болгон эмхэтгэн нийтэлсэн. “Монголын улс төр: онол, номлол, нийтлэл” хэмээх нэгдүгээр ботид Улс төрийн шинжлэх ухааны онол, арга

зүйн асуудалд, Улс төрийн сэтгэл судлал ба хүчирхийллийн сэтгэл зүй, Массын улс төрийн оролцоо ба улс төрийн сэтгэлзүйн шинжилгээ, Улс төрийн өөрчлөлт, үзэл суртал, Улс төрийн институт, үйл явц, гадаад бодлого гэсэн бүлгүүдийн хүрээнд бичиж туурвисан эрдэм шинжилгээний бүтээлүүдийг хамруулсан бол “Монголын улс төр: уламжлал, шинэчлэл, тэмдэглэл” хэмээх хоёрдугаар ботид Улс төрийн онол, үзэл баримтлал, Ардын уламжлал, эх оронч ухамсар, Монгол дахь улс төрийн шинэчлэл ба модернизаци, Монголын улс төрийн систем, сонгууль, иргэдийн оролцоо зэрэг сэдвүүдийн хүрээнд туурвисан эрдэм шинжилгээний бүтээлүүд, докторын зэрэг горилон бичсэн диссертаци зэргийг эмхэтгэн хэвлэсэн болно. “Монголын улс төр: судалгаа, шинжилгээ, үнэлгээ” сэдэвт гуравдугаар ботид Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгууль, парламентын гишүүдийн имиж, сонгогчдын санаа бодол, ардчилал, улс төрийн намууд, бүс нутгийн аюулгүй байдал зэрэг асуудлаар хийсэн судалгааны дүгнэлт, харьцуулалт, үр дүнг авч үзсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, нийтлэл зэргийг эмхэтгэн оруулжээ.

Хүснэгт 1. МУИС-ийн Улс төр судлалын тэнхимд ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа багш нарын хамгаалсан эрдмийн зэрэг, судалгааны ажлын сэдэв (1969-2025 оны хооронд)

№	Нэр	Эрдмийн зэрэг	Судалгааны ажлын сэдэв	Хамгаалсан он	Хамгаалсан сургууль
1	Д.Содномгомбо	Философийн ухааны дэд эрдэмтэн	БНМАУ-д нийгмийн зөрчлийг шийдвэрлэсэн зарим асуудал	1969	Эрхүүгийн их сургууль
2	Т.Хүрэлбаатар	Философийн ухааны дэд эрдэмтэн	Хөдөлмөрийн ухамсар	1979	Москвагийн улсын их сургууль
3	С.Базарпүрэв	Доктор (Ph.D)	Оюуган залуусын нийгмийн идэвхтэй байр суурийг төлөвшүүлэх асуудал	1989	Москвагийн улсын их сургууль
4	Ш.Содном	Доктор (Ph.D)	Хөдөлмөрт хандах социалист харилцааны төлөвшилтийн диалектик	1990	Киевийн их сургууль

5	Ц.Ганболд	Доктор (Ph.D)	Ардын уламжлал ба эх оронч ухамсар	1991	МУИС
6	А.Юндэндорж	Доктор (Sc.D)	Особенности политической системы Монголии в условиях перехода к конституционализму	1994	Москвагийн Улсын Их Сургууль
7	Д.Оюунчимэг	Магистр	Улс төрийн лидерийн имиж	1996	МУИС
8	Х.Ганбаатар	Магистр	Монгол Оросын улс төрийн харилцаа	1997	МУИС
9	Ё.Довчин	Доктор (Ph.D)	Степная политическая культура	1999	Санкт-Петербургийн их сургууль
10	Ж.Төртогтох	Доктор (Ph.D)	Үндсэн хуулийн политологийн шинжилгээ (Монгол улсын Үндсэн хуулийн жишээн дээр)	2002	МУИС
11	Д.Бадамдаш	Магистр	Зүүн Европын Пост коммунист орнууд дахь улс төрийн модернизаци	1999 / 2003	МУИС / Охайо их сургууль
12	Ц.Батболд	Доктор (Ph.D)	Монголын улс төрийн системийн өөрчлөлт дэх төрийн бюрократ удирдлагын хөгжил, төлөвшилт, түүнийг боловсронгуй болгох нь	2008	МУИС
13	С.Мөнхбат	Доктор (Ph.D)	Монгол дахь улс төрийн намын бүтэц, дотоод зохион байгуулалт	2009	МУИС
14	Ч.Өлзийсайхан	Доктор (Ph.D)	Ардчилсан шилжилтийн үеийн Монголын улс төрийн элитийн төлөвшилд	2009	МУИС
15	Г.Цэнд-Аюуш	Доктор (Ph.D)	Монголын нийгмийн улс төрийн ухамсрын хувьслын зарим асуудал	2011	МУИС
16	Г.Туяагэрэл	Доктор (Ph.D)	Улс төрийн хямрал судлалын онол арга зүйн асуудлууд	2012	МУИС

17	Д.Бумдарь	Доктор (Ph.D)	Establishment of Diplomatic Relations between Japan and Mongolia (1972)	2013	Кокушикан Их сургууль
18	Д.Ундрах	Доктор (Ph.D)	Парламентын ёс зүйн онол, практикийн асуудалд	2015	МУИС
19	Б.Эрдэнэдалай	Доктор (Ph.D)	Монгол дахь улс төрийн намын санхүүжилт: улс төр – эрх зүйн шинжилгээ	2015	МУИС
20	Д.Түмэнжаргал	Доктор (Ph.D)	Орчин үеийн Монгол улсын ардчилсан сонгуулийн тогтолцооны хэлбэр болон өөрчлөлтийн судалгаа	2017	Жилин их сургууль
21	О.Мөнхжаргал	Магистр	How can participatory and deliberative democratic practices help to sustain inclusive development in Mongolia?	2018	Манчестерийн их сургууль
22	Т.Есүхэй	Магистр	Хөгжлийн бодлого төлөвлөлт, боловсруулалтын шинжилгээний арга зүй	2020	МУИС
23	Э.Саранцэцэг	Доктор (Ph.D)	Voting behavior and political support of Mongolian voters: The 2020 Mongolian legislative election	2021	Сүншил Их Сургууль
24	О.Машбат	Доктор (Ph.D)	Парламентын улс дахь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хооронд хяналт-тэнцлийн зарчим хэрэгжих онцлог, өнөөгийн асуудал	2023	Шихихутуг их сургууль
25	Д.Уртнасан	Доктор (Ph.D)	Монгол дахь улс төрийн хүнийсэлт, түүний зарим индикатор	2024	МУИС

**Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн тойм**

Монгол Улсын Их сургуулийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг Политологи эрдэм шинжилгээний бичиг 2002 онд анхны дугаараа гаргаснаас хойш 2024 оны байдлаар нийт 22 дугаар хэвлэгдэн гарчээ. Энэ хугацаанд тус эрдэм шинжилгээний бичигт дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн давхардсан тоогоор 617 эрдэмтэн, судлаачдын хамтарсан болон бие даасан 442 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгджээ. Үүнд МУИС-ийн нийгмийн ухааны салбарын эрдэмтэн судлаачдаас гадна МУИС-ийн ОУХНУС, ГХСС, МХСС, мөн МУБИС, ШУТИС-ийн ХУС, БУХС, ХААИС-ийн ЭЗБС, ХИС-ийн ОУХНУС, СЭЗИХ-ийн ГХС, Улаанбаатар Эрдэм их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дүн шинжилгээний алба, Удирдлагын Академи, ШУА-ийн ФСЭХ, БНСУ-ын Сөүлийн Үндэсний их сургууль, Сүншил их сургууль, Кёнсан Үндэсний их сургууль, АНУ-ын Итака коллеж, Аризонагийн их сургууль, БНХАУ-ын Донгбэй СЭЗИС, Жилиний их сургууль, Буриадын улсын их сургууль, Токиогийн их сургууль, Хитоцүбаши их сургууль, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбар, Өвөр Монголын их сургууль, Новосибирскийн Улсын их сургууль, Новосибирскийн ШУА-ийн ФЭХ, Чехийн Jan Evangelista purkyně их сургууль зэрэг дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн эрдэмтэн судлаачдын бүтээл багтсан байна.

Хүснэгт 2. Политологи эрдэм шинжилгээний бичиг сэтгүүлийн дугаарууд, тэдгээрт хэвлэгдсэн өгүүллийн нэгдсэн тойм

№	Он	Хэвлэлийн дугаар	Нийт өгүүллийн тоо	Нийт зохиогчийн тоо	Гадаад зохиогч	Гадаад хэл дээрх өгүүлэл
I	2002	№189 (15)	16	17		
II	2005	№246 (28)	20	23	1	
III	2007	№281 (40)	21	25		
IV	2009	№297 (50)	22	25	2	
V	2009	№325 (51)	17	22		
VI	2010	№332 (58)	16	17	3	
VII	2011	№348 (61)	15	18		
VIII	2011	№350 (62)	18	22		
IX	2012	№372 (66)	20	25	2	
X	2013	№10 (388)	26	31		1
XI	2014	№402 (11)	26	39	3	2
XII	2015	№12 (419)	32	53	4	1
XIII	2016	№(13) 442	32	53		
XIV	2017	№14 (464)	25	43		
XV	2017	№15 (476)	17	21		1
XVI	2018	№16 (489)	17	24		1
XVII	2019	№17 (505)	13	24	2	
XVIII	2020	№18 (534)	14	21	2	
XIX	2021	№19 (558)	16	24	1	2
XX	2022	№20 (570)	19	39	1	
XXI	2023	№21 (571)	17	33	5	4
XXII	2024	№22 (593)	23	42	1	
<b>Нийт</b>			<b>442</b>	<b>617</b>	<b>27</b>	<b>12</b>

Тус сэтгүүлд хэвлэгдэн гарсан эрдэм шинжилгээний өгүүлүүд нь улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүй, мэдлэг, мэдээллийн өргөн агуулгыг багтаасан бөгөөд дараах дэд сэдвүүдийн хүрээнд ангилж үзвэл:

- Улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүйн асуудал- нийт 119 өгүүлэл
- Улс төрийн институт, улс төрийн үйл явц- нийт 119 өгүүлэл
- Ардчилал онол, практик- нийт 50 өгүүлэл
- Улс төр, нийгэм, төрийн бодлого ба төрийн удирдлага- нийт 25 өгүүлэл
- Гадаад бодлого, олон улсын харилцаа, геополитикийн асуудал- нийт 29 өгүүлэл
- Улс төрийн сэтгэлгээний түүх ба орчин үе- нийт 23 өгүүлэл
- Харьцуулсан улс төр, эмпирик судалгаа- нийт 47 өгүүлэл
- Улс төрийн шинжлэх ухааны тайлан, танилцуулга мэдээ, сургалт, судалгаа, сурталчилгаа- нийт 25

Түүнчлэн улс төр судлаачид, шинжлэх ухааны байгууллагууд, улс төр судлалын чиглэлээр суралцаж буй оюутан, суралцагчдын танин мэдэхүйд зориулан улс төрийн нэр томъёоны тайлбар, эрдэмтдийн намтар зэргийг цувралаар хэвлэж ирсэн.

Улс төрийн шинжлэх ухааны эрдэмтэн, судлаачдын цар хүрээг нэмэгдүүлэх, олон улс болон Монгол Улсад шинэ тутамд хөгжиж буй улс төрийн шинжлэх ухааны онол, арга зүй, судалгааны чиглэл, хандлагыг түгээн дэлгэрүүлэх үүднээс орос, англи, монгол дээр гадаад, дотоодын эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээний өгүүлүүдийг тогтмол оролцуулж иржээ. Тухайлбал, АНУ-ын Итака коллеж, Улс төрийн шинжлэх ухааны тэнхимийн доктор Томас Шевори “Дижитал эриний үеийн улс төрийн коммуникаци”, МУИС-ийн зочин профессор Удо Б.Баркман “Монгол дахь улс төрийн ба ардчиллын үйл явц”, Новосибирскийн Улсын их сургуулийн профессор Попков Юрий Владимирович болон Новосибирскийн ШУА-ийн ФЭХ-ийн эрдэмтэн Тюгашев Евгений Александрович нарын “Ценности, которые создали Монголию.../Трансевразийская перспектива/”, доктор Томас Шевори “Төрийн албан хаагчийн ёс зүйн байдал: АНУ ба Монгол Улс” (доктор Д.Ундрахтай хамтран), БНСУ-ын магистрант Лий Дэ Хаг “БНСУ-ийн төрийн бус байгууллага болон монголын төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа /Цөлжилтийн асуудлаар голчлон хамтын ажиллагаа/”, АНУ-ийн Аризона их сургуулийн антроплогийн ухааны докторант Анника Эриксон “Говийн малчдын зудын эрсдэлийн тухай санал: малчид болон засгийн газар хоёулаа хариуцлагатай байх ёстой”, БНХАУ-ийн Донгбэй СЭЗИС-ийн төрийн удирдлагын дэд профессор Ху Ши Чيان “Төр, нийгмийн харилцааг судлах нь: Хятадын иргэний нийгмийн сэдэв”, профессор Икеда Сого “Япон улсын засгийн газраас явуулж байгаа Монголд чиглэсэн гадаад бодлого”, МУИС-ийн улс төр судлалын докторант Пак Жон Хү “Energy security and role of hegemon” (профессор Ж.Төртогтохтой хамтран), профессор Миюри Нобуюки “Япон улсын улс төрийн өнөөгийн байдал, зарим тулгамдсан асуудал /Парламентын 2013 оны сонгууль, түүний үр дүн/, БНХАУ-ийн Жилиний их сургуулийн профессор Zhou Guang Hui “Монголын сонгуулийн тогтолцоо, түүний хувьсал өөрчлөлт, хэрэгжилтийн асуудал” (доктор Д.Түмэнжаргалтай хамтран), МУИС-ийн улс төр судлалын докторант Пак Жон Хү, “Пак Жон Хүй-гийн засаглалын эрх мэдлийн бүтэц болон эдийн засгийн бодлогын онцлог” (профессор Ж.Төртогтохтой хамтран), Буриадын улсын их сургуулийн доцент, доктор А.В.Михалев “Концепция <<мягкой силы>>: обзор подходов в зарубежной науке”, БНСУ-ын Кёнсан Үндэсний их сургуулийн профессор Пак Чун Чол “Монгол солонгосын түншлэлийн харилцааны тойм ба өнөөгийн байдал”, Токиогийн их сургуулийн судлаач Зэн-у Хотта болон Токиогийн Метрополитан их сургуулийн судлаач Масото Эгучи “Аман-мэдээлэл (А-М) ба Цахим-Аман-Мэдээлэл(Ц-А-М)-д өгөх

Сонгогчдын үйл байдлын хариулт”, ОХУ-ын ШУА-ийн Сибир салбарын Монгол, Төвд, Буддын судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Дамдин Д.Бадараев “Ардчиллын төлөөх үйл явцын өрнөл ба эрх чөлөөнд тэмүүлэхүй” (доктор О.Хатанболдтой хамтран), Өвөр Монголын их сургуулийн профессор Э.Наран “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорын нөхцөл байдалд Хятад Монголын хамтран элсэн шуургаас сэргийлэх тухай анхны шинжилгээ”, Чехийн Jan Evangelista purkyně их сургуулийн доктор Pavel Mařkarinec “The Development and Transformation of Mongolia’s Party System, 1992-2020”, “Dynamics and Changes of the Executive-parties Dimension of the Mongolian Democracy and its Effect on Democratic Performance”, МУИС-ийн ОУХНУС-ийн докторант Катанода Томоки “Японы өсөлтийг дэмжсэн “Япон маягийн менежмент”- Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх мэдлэг”, БНСУ-ын Сөүлийн Үндэсний их сургуулийн Ази судлалын төвийн судлаач Hyun-Chin Lim болон профессор Suk-Ki Kong нар “Drifting Civil Society in South Korea: De-globalization, Populism, and Digital Revolution”, судлаач Nicholas Natzke (судлаач Г.Золзаяа, Г.Жаргалмаа нартай хамтран) “Mongolian Youth’s Attitudes Towards Democracy and Government”, Японы Хитоцүбаши их сургуулийн Institute for Global Governance Research-ийн судлаач Sascha Hannig Núñez “Changes in Political Culture among Younger Generations Trigger Loss in Trust in Democracy and Preference for Technocratic Alternatives” зэрэг гадаад улсын зохиогчдын бичсэн өгүүллүүд орос, монгол, англи зэрэг хэлээр хэвлэгджээ.

Улс төр судлалын тэнхимийн дэргэдэх улс төрийн сургалт судалгааны “Альтернатив төв” ТББ-аас 2003 онд Улс төрийн шинжлэх ухааны Альтернатив сэтгүүлийн нэгэн дугаарыг эрхлэн гаргаж, нийт 15 зохиогчийн 13 өгүүлэл хэвлэгдсэн байна.

Түүнчлэн МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлийн стандарт шаардлагад нийцүүлэн англи хэл дээр “Contemporary Political Society” сэтгүүлийг 2011 оноос 2017 оны хооронд эрхлэн гаргасан бөгөөд нийт таван дугаарт дотоодын 15, гадаадын 66 нийт 81 зохиогчийн 61 өгүүлэл хэвлэгджээ.

### Хүснэгт 3. “Contemporary Political Society” сэтгүүлийн товч мэдээлэл

Дугаар	Огноо	Хэвлэлийн дугаар	Нийт өгүүллтийн тоо	Нийт зохиогчийн тоо
I	2011	Vol.1 No.1	6	6
II	2012	Vol.2 No.1/2	5	7
III	2015	Vol.3 No.1	27	34
IV	2016	Vol.4 No.1	14	23
V	2017	Vol.5 No.1	9	11
Нийт			61	81

### Дүгнэлт

“Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны төв - МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрдэм шинжилгээний бүтээлийн товч тойм” сэдэвт энэхүү өгүүлэл нь удиртгал, МУИС-ийн Нийгмийн ухааны факультетын Шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхимийн товч түүх, Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны анхны тэнхимийн үүсэл, хөгжлийн товч түүх, Улс төр судлалын тэнхимийн багш нарын бичиж, хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тойм, Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн тойм гэсэн хэсгүүдээс бүрдсэн болно.

МУИС-ийн Нийгмийн ухааны факультетын Шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхимийн товч түүх хэсэгт Улс төр судлалын тэнхимийн үндэс суурь тавигдсан түүхийг профессор Ц.Ганболдын бичсэн “ШУКО-оос улс төр судлал хүртэл” номын холбогдох хэсгийн агуулгад үндэслэн товч хураангуйлан оруулав. Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны анхны тэнхимийн үүсэл, хөгжлийн товч түүх хэсэгт мөн уг номын холбогдох хэсгийн агуулгад үндэслэн товч хураангуйлан оруулав.

Улс төр судлалын тэнхимийн багш нарын бичиж, хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тойм хэсэгт багш нарын дангаар болон хамтран бичсэн нэг сэдэвт зохиол, ном сурах бичиг, дотоод гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл, үндэсний хэмжээнд болон 20 гаруй олон улсад зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал семинарт хэлэлцүүлсэн илтгэл, судалгааны төсөл, сэдэвт ажил, бодлогын судалгааны талаарх тойм мэдээллийг нэгтгэн оруулав. Мөн энэ хэсэгт 1969 оноос 2020 он хүртэлх тус тэнхимд ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа багш нарын хамгаалсан эрдмийн зэргийн талаарх мэдээллийг хүснэгтлэн оруулсан болно. Багш нарын бичиж хэвлүүлсэн бүтээлүүдийн тоон мэдээллийг гаргахдаа Улс төр судлалын тэнхимийн мэдээллийн санд байгаа хэвлэмэл бүтээлүүд, багш нарын товч намтар, танилцуулга, бүтээлийн жагсаалт зэрэгт тулгуурлан ойролцоогоор нэгтгэн гаргасан тул зарим тоо мэдээлэл тодорхой хэмжээнд зөрүүтэй байх боломжтой.

Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн тойм хэсэгт 2002 оноос хойш тус тэнхимээс эрхлэн гаргаж буй Политологи сэтгүүл, тэнхимийн дэргэдэх сургалт судалгааны Альтернатив төв ТББ-ээс 2003 онд эрхлэн гаргасан Альтернатив сэтгүүл, тэнхимийн дэргэдэх Орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс 2011-2017 оны хооронд эрхлэн гаргасан Contemporary Political Society зэрэг сэтгүүлүүдийн талаарх мэдээллийг нэгтгэн тоймлов. Ном зүйд өгүүллийг бичихэд ашигласан зарим түүхэн эх сурвалж, Улс төр судлалын тэнхимийг үүсгэн байгуулж, ажиллаж байсан ахмад эрдэмтэн багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлүүд, тэнхимийн багш нарын зарим хамтын бүтээлүүд, тус тэнхимээс зохион байгуулсан зарим эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлүүд, Политологи зэрэг эрдэм шинжилгээний сэтгүүлүүд, цувралуудын бүрэн жагсаалтыг оруулсан болно.

## Ном зүй

1. Монголын улс төр судлаачдын нэгдсэн холбоо. (2010). Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжил, хандлага. *Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжил, хандлага*. Улаанбаатар: Бишрэлт тэнгэр.
2. Janar, T. (2016). The development of political science in Mongolia: Initiatives and challenges”. *Asian Journal of Comparative Politics*, 1(2), 108-122.
3. Janar, T., & Chabal, P. (Хянд.). (2011-2017). *Contemporary Political Society №1-№5*. Улаанбаатар: Удам соёл.
4. Альтернатив судалгааны төв. (2003). *Улс төрийн шинжлэх ухааны Альтернатив сэтгүүл*. Улаанбаатар.
5. Ганболд, Ц. (2012). *ШУКО-оос Улс төр судлал хүртэл*. Улаанбаатар: Соёмбо принтинг .
6. Ганболд, Ц. (2020). *Монголын улс төр: онол, номлол, нийтлэл – I боть*. Улаанбаатар: МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал.
7. Ганболд, Ц. (2020). *Монголын улс төр: судалгаа, шинжилгээ, үнэлгээ – III боть*. Улаанбаатар: МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал.

8. Ганболд, Ц. (2020). *Монголын улс төр: уламжлал, шинэчлэл, тэмдэглэл – II боть*. Улаанбаатар: МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал.
9. Конрад-Анденауэр-Сан, & МУИС. ШУС. Улс төр судлалын (Хянд.). (2017). *Үр нөлөө бүхий нутгийн удирдлагын тогтолцоо*” судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
10. Конрад-Анденауэр-Сан, & МУИС. ШУС. Улс төр судлалын (Хянд.). (2018). *Монгол улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа: Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
11. Конрад-Анденауэр-Сан., & МУИС. ШУС. Улс төр судлалын (Хянд.). (2019). *Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь*” судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
12. Монголын улс төр судлаачдын нэгдсэн холбоо. (2010). Монголын улс төр асуудал, эрэл, шийдэл. *Монголын улс төр асуудал, эрэл, шийдэл: Эрдэм шинжилгээний бага хурал №2*. Улаанбаатар: Бишрэлт Тэнгэр.
13. Монголын улс төр судлаачдын нэгдсэн холбоо. (2012). Ардчилал: асуудал, эрэл, шийдэл. *Ардчилал: асуудал, эрэл, шийдэл” эрдэм шинжилгээний бага хурал №3*. Улаанбаатар: Бишрэлт тэнгэр.
14. Монголын улс төр судлаачдын нэгдсэн холбоо. (2014). Улс төрийн нам: асуудал, эрэл, шийдэл. *Улс төрийн нам: асуудал, эрэл, шийдэл эрдэм шинжилгээний бага хурал, (хуудсд. Улс төрийн нам: асуудал, эрэл, шийдэл)*. Улаанбаатар.
15. МУИС. (2001). *Улс төрийн шинжлэх ухаан*. Улаанбаатар: Экимто .
16. МУИС. (2010). *"Улс төрийн шинжлэх ухаан" сурах бичиг (Хоёр дахь хэвлэл)*. Улаанбаатар: Экимто .
17. МУИС. (2014). *"Улс төрийн шинжлэх ухаан" сурах бичиг*. Улаанбаатар: Экимто.
18. МУИС. (2017). Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжил эрдэм шинжилгээний бага хурал. • *МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн 50 жилийн ойд зориулсан Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжил” эрдэм шинжилгээний бага хурал*. Улаанбаатар.
19. МУИС. (2017). Орчин үеийн улс төрийн хөгжил хандлага. *Орчин үеийн улс төрийн хөгжил хандлага” эрдэм шинжилгээний бага хурал*. Улаанбаатар.
20. МУИС, Улс төр судлалын тэнхим. (2002-2024). *Эрдэм шинжилгээний Политологи сэтгүүл №1-№22*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
21. МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Хууль зүйн үндэсний хүрээлэн, & Монголын улс төр судлаачдын холбоо. (2020). Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ. *Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ хурал*. Улаанбаатар: ХЗҮХ хэвлэх үйлдвэр.
22. НШУС. Улс төр судлалын тэнхим. (2012). *Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг (XX зуун)*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
23. Содном, Ш. (2020). *Улс төр судлалын онол, практикийн асуудлууд*. Улаанбаатар: МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал.
24. Содномгомбо, Д. (2020). *Улс төр судлалын мэдлэгт -II боть*. Улаанбаатар: МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал.
25. Содномгомбо, Д. (2020). *Философи, улс төрийн философийн мэдлэгт - I боть”*. Улаанбаатар: МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал.

26. Төрийн байгуулалтын экспертийн зөвлөл (Хян.). (2023). *Монголд төлөөллийн ардчиллын институтууд чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байна вэ*. Улаанбаатар.
27. Төртогтох, Ж., & Ганзаяа, С. (Хянд.). (2021). *Монгол дахь засаглал, институт, оролцоо, тэгш байдлын тулгамдсан асуудал, цаашидын хандлага” судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж*. Улаанбаатар: Адмон принтинг.
28. Төртогтох, Ж., & Ганзаяа, С. (Хянд.). (2023). *Цахим засаглал: төрийн үйлчилгээ, шийдвэр гаргах үйл явц, мэдээлэл харилцааг цахимжуулах боломж*. Улаанбаатар: Адмон принтинг.
29. Төртогтох, Ж., & Мөнхбат, С. (Хянд.). (2020). *Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг*. Улаанбаатар: Адмон.
30. Төртогтох, Ж., Амаржаргал, П., & Ганболд, Ц. (Хянд.). (2019). *Парламентын институтийн улс төр, эрх зүйн шинжилгээ. Парламентын институтийн улс төр, эрх зүйн шинжилгээ” хурал*. Улаанбаатар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр.
31. Төртогтох, Ж., Амаржаргал, П., & Ганзаяа, С. (Хянд.). (2020). *“Монгол дахь ардчилал, иргэнийн нийгмийн өнөөгийн байдлын нийгэм – улс төрийн судалгаа” судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж*. Улаанбаатар.

## **BRIEF OVERVIEW OF THE RESEARCH WORKS OF THE DEPARTMENT OF POLITICAL SCIENCE OF THE NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA AS A POLITICAL SCIENCE RESEARCH AND TEACHING CENTER IN MONGOLIA**

### **Abstract**

Within the frame of this article, the purpose of summarize a brief history of the establishment of the Department of Political Science at the National University of Mongolia, a review of the collaborative research work of the department's faculty, and detailed information about the academic journals published by the department. The history of the Department of Political Science was summarized in the following sections: A brief history of the Department of Theory of Scientific Communism of the Faculty of Social Sciences at the National University of Mongolia, and a brief history of the origin and development of the first modern Department of Political Science in Mongolia. The review of the research work of the Department of Political Science includes collaborative research works of the department's faculty, academic journals published by the department, books, research articles written and published by the department's faculty, presentations at domestic and foreign academic conferences, and research project summaries.

**Keywords:** political studies, political science, Department of Political Science